





12-Р АНГИ



**Шалгалтын
дэвтэр**



Сургууль.....
Сурагч.....
Анги.....
Бүлэг.....
Хувилбар.....
Шифр.....

Ерөнхий агуулга

Энэхүү шалгалт нь гурван хэсгээс бүрдэх бөгөөд Үүнд:

- 1. Сонгох даалгавар: Сонгох даалгавар 37*
- 2. Задгай даалгавар: Задгай даалгавар 3*
- 3. Хариултын хэсэг*

Ерөнхий санамж

- 1. Даалгавар бүрийн өгүүлбэрийг сайтар уншин, даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгээрэй*
- 2. Хэсэг бүрийн төгсгөлд байгаа хариулт бичих хүснэгтэд даалгавар бүрийн сонгосон хариултыг засваргүй бичнэ үү.*
- 3. Хугацааг маш сайн тооцоорой.*


Амжилт хүсье

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР
2025.06.06



**ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ/ 12-Р АНГИ/
80 МИНУТ**

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР:

1. Канадын жуулчин Сингапур улс руу аялахаар шийджээ. Аялагчид Сингапур улсын бодит талбай хэрэгтэй байгаа байна юм. Тэгвэл ямар тусгаг ашигласан Сингапур улсын зураг жуулчинд шаардлагатайг олно уу. /1оноо/
A. Тэнцүү өнцөгт конус B. Тэнцүү зайт конус
C. Тэнцүү талбайт цилиндр D. Тэнцүү зайт азимут .
2. 1500 оноос хойших Дэлхийн хүн амын шилжилтын зурагт ямар дүрслэлийн ашиглан зурагласан бэ? Аль тивээс ямар тиврүү хүн амын шилжих хөдөлгөөн их явагдсан байна вэ? /1оноо/




- A. Хөдөлгөөнт шугамын арга, Азиас Америк руу
B. Хөдөлгөөнт шугамын арга, Европоос Америк руу
C. Ижил шугамын арга, Америкаас Европ руу
D. Ижил шугамын арга, Европоос Австрали руу
E. Хөдөлгөөнт шугамын арга, Азиас Африк руу
3. Google Earth ашиглан Эйфелийн цамхагийг зурагт үзүүлсэн зургийг ажиглан үнэн зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой. /1оноо/




- A. Эйфелийн цамхагийн солбилцол нь X.Ө $48^{\circ} 51'$, 3.У $2^{\circ} 17'$, Сена мөрөн баруун хойд хэсгээр урсаж байна.
- B. А.Эйфелийн цамхагийн солбилцол нь X.Ө $48^{\circ} 51'$, 3.У $2^{\circ} 17'$, Сена мөрөн зүүн өмнөд хэсгээр урсаж байна.
- C. Эйфелийн цамхагийн солбилцол нь 3.У $48^{\circ} 51'$, X.Ө $2^{\circ} 17'$, Сена мөрөн баруун хойд хэсгээр урсаж байна.
- D. Эйфелийн цамхагийн солбилцол нь 3.У $48^{\circ} 51'$, X.Ө $2^{\circ} 17'$, Сена мөрөн өмнөд хэсгээр урсаж байна.

- D.Эйфелийн цамхагийн солбилцол нь Х.Ө $48^{\circ} 51'$, З.У $2^{\circ} 17'$, Сена мөрөн зүүн хэсгээр урсаж байна.
4. Дараах гарагуудаас “Дэлхий төст” гарагт ХАМААРАХ гарагийг сонгоно уу /1оноо/
 А. Бархасбадь В. Сугар С. Санчир D.Тэнгэрийн ван
5. Дараах 2 зургийг харьцуулан дэлхийн хүн амын хамгийн их тархсан өргөрөг, байгалийн нөхцөлийг зөв



Зураг 2.9. Дэлхийн хүн амын тархалтыг өргөрөгөөр авч үзвэл ялгаатай.


тодорхойлсон хувилбарыг сонгоорой. /1оноо/



7. Өгөгдсөн чулууны зургийг ашиглан, ямар гарал үүсэлтэй болохыг сонгоно уу. /1оноо/



- A. Хувирмал В. Тунамал С. Хүрмэн D. Магмын
8. Эндоген үйл явцад аль орохгүй вэ? /1оноо/
- A. Салхи В. Тектоник хавтангийн хөдөлгөөн С. Галт уулшил D. Газар хөдлөлт
9. Дэлхийн галт уулын тархалтанд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлийг сонгоорой . / 2оноо /



- A. Дэлхийн томоохон уулсын систем их нөлөөлсөн
- B. Тектоник хавтангуудын хил зааг их нөлөөлсөн.
- C. Далай, эх газар хоёрын зааг их нөлөөлсөн
- D. Евроази ба Номхон далай хоёр их нөлөөлсөн.
10. Газрын гадаргын рельефийн хэлбэрийг ажиглан ямар хүчин зүйлс хамгийн их нөлөөлсөн бэ? /1оноо/



Зураг 3.20. Боржингийн өгөршил (Бага газрын чулуу, Дундговь, Дэлгэрцогт) Эх сурвалж: <http://www.touristinfocenter.mn>

- A. Газар хөдлөлт В. Галт уулшил

C. Тектоник хавтангийн хөдөлгөөн D. Экзоген үйл явц

11. Дараах хүснэгтийг ажиглан хамгийн өндөр хөгжилтэй улсыг сонгоно уу. /1оноо/

Улс	Хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувь (%)	Хүн амын дундаж наслалт	Нэг хүнд ногдох ДНБ (ам.дол)	Насанд хүрэгчийн бичиг үсэг тайлагдалт (%)	Шинжлэх ухаанд зарцуулах ДНБ (%)
Швейцарь	15	82	83383	100	3
Чили	21	78	14394	99	0.39
Хятад	19	74	5445	94	1.47
Монгол	28	69	3129	97	0.24
Кени	42	52	808	87	0.1

A. Монгол B. Чили C. Хятад D. Швейцарь

12. Алтай язгуурын хэлний тархалтыг зөв тодорхойлсон хариуг олоорой. /1оноо/

A. Европ ба Хойд Америк B. Төв болон Зүүн Ази
C. Өмнөд Америк D. Өмнөд Африк

13. Зургийг ажиглан дараах асуултанд хариулна уу. /1оноо/

Ислам буюу Лалын шашны гол урсгалууд дэлхийн ямар бүс нутаг түлхүү тархсан байна вэ?

A. Хойд Африк ба Өмнөд Америк B. Зүүн Ази ба Зүүн өмнөд ази
C. Хойд Африк ба Баруун өмнөд Ази D. Хойд Америк ба Австрали

14. Сири улсын дүрвэгсэд тухай кейс уншиж хүн амын шилжих хөдөлгөөнд нөлөөлсөн гол хүчин зүйлийг сонгоорой. /1оноо/

2014оны байдлаар Сири улсын 2.6 сая дүрвэгсэд НҮБ-д бүртгэгдсэн. Улс төр, нийгмийн тогтворгүй байдал ихээхэн нөлөөлсөн бөгөөд тэд хил залгаа орших Ирак, Израйл, Кипр, Иордан, Леван зэрэг олон орнуудад дүрвэн гардаг.


A. Байгалийн гамшигт үзэгдэл B. Иргэний дайн явагдсан
C. Ган гачиг давтамж ихсэлт D. Ажлын байрны хомсдол

15. Хотын суурингийн дээд хэлбэр нь аль улсад байдаг вэ? /1оноо/



A. Монгол B. Балба C. АНУ D. Ватикан

16. Сахарын нишингийн тариалдаг улс орнуудыг улаан өнгөөр картограмм аргаар зурагласан зураг өгөгджээ. Тэгвэл ямар уур амьсгалтай газар голлон тариалдаг болохыг тодорхойлно уу. /1оноо/




- A. Сэрүүн бүсийн хүйтэн, хуурай уур амьсгалтай газар
 B. Арктикийн сэрүүн уур амьсгалтай газар
 C. Тропикийн хуурай, гандуу уур амьсгалтай газар
 D. Экватор болон тропикийн дулаан, чийглэг уур амьсгалтай газар
17. Өрхийн аж ахуйн онцлог шинжэд тохирох хувилбарыг сонгоно уу. /1оноо/
 A. Хөрөнгө мөнгө ихтэй, заримдаа олон улсын компаниас хийгддэг.
 B. Ургацаа хамгаалахын тулд хортон шавьжны хор их хэмжээгээр ашигладаг.
 C. Үр нь шинэ чанартай сортоор тариалдаг
 D. Ажиллах хүч нь өрхийн гишүүд
18. Аж үйлдвэрийн байршилд нөлөөлөх байгалийн хүчин зүйлс аль нь орохгүй вэ? /1оноо/
 A. Хөрөнгө B. Байршил C. Түүхий эд D. Уур амьсгал
19. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу.
 Химийн үйлдвэр нь хортой салбарт хамаарагддаг бөгөөд Япон нь хуванцар материал, сав суулганы үйлдвэрээ Филиппинд байршуулж зөвхөн бэлэн бүтээгдэхүүнээ Япон улс авч байна. Үүнийг нэг төрлийн (.....) гэж үздэг. /1оноо/
 A. Улс төрийн колончлол B. Экологийн колончлол
 C. Нийгмийн колончлол D. Эдийн засгийн хямрал
20. Олон улсын газарзүйн хөдөлмөрийн хуваарьт уул уурхайн олборлолтоор зонхилох нөлөөг үзүүлдэг орнуудад аль улс нь БАГТАХГҮЙ болохыг олно уу /1оноо/
 A. Хятад B. ОХУ C. Австрали D. Япон
21. Өнөө үед газрын тосыг аль чиглэлийн замаар бага тээвэрлэж байгааг тодорхойлно уу

Дорнод аймгийн Боловсролын газар

/2 оһоо /

- A. Персийн булангаас Япон, Баруун Европ, АНУ руу
B. Торгоны замаар Төв Ази, Европ руу
C. Баруун Сибирээс Европ руу
D. Карибын тэнгисээс АНУ руу

22. Гурвалжингийн диграмм ашиглан үйлчилгээний салбар хамгийн өндөр хөгжсөн орныг сонгоно уу. /1оноо/




- A. Өмнөд Солонгос
B. Япон
C. Шриланк
D. Вьетнам

23. Аялал жуулчлалын салбар хөгжихөд эерэг нөлөөтэй хүчин зүйлийг тодорхойлоорой. /1оноо/

- A. Үйлчилгээний салбар өндөр хөгжсөн
B. МAA-н салбар өндөр хөгжсөн
C. Уул уурхайн салбар өндөр хөгжсөн
D. Олборлох салбар өндөр хөгжсөн

24. Дараах зургийг ажиглаад “Г” дугаараар тэмдэглэсэн цацрагийн төрлийг сонгоорой. /1 оноо/



- A. Сарнисан цацраг
B. Нийлмэл цацраг
C. Агаар мандалд шингэсэн цацраг
D. Газрын гадаргаас ойсон цацраг


25. Нарны гэрэл дэлхийн гадаргад жигд шулуунаар тусдаг боловч газар нутгууд дулаан, хүйтнээрээ ялгаатай уур амьсгалын бүслүүр үүссэн байдгийн үндсэн шалтгааныг сонгоно уу. /1 оноо/

- A. Ургамлын төрөл зүйл ялгаатайгаас В. Дэлхий бөмбөрцөг хэлбэртэйгээс
C. Үүлшилт харилцан адилгүйгээс D. Гадаргын ойлгох чадвар ялгаатайгаас

26. Экватор, түүний орчмоор орших бөгөөд хоёр талаасаа жилийн +20C-ийн изотермээр зааглагдана. Энэ бүслүүр нь хуурай газарт дал модны, далайд шүрийн тархсан хязгаартай давхцана. Тус дулааны бүслүүрийг зөв сонгоорой. /1 оноо/

- A. Хүйтэн бүслүүр B. Халуун бүслүүр
- C. Сэрүүн бүслүүр D. Мөнх хүйтний бүслүүр

27. Зургийг ажиглан агаарын даралтын өндрийн хуваарилалтын зүй тогтлыг зөв илэрхийлсэн хариуг олоорой. /1 оноо/



- A. Өндөр болох тусам агаарын даралт ихсэж байна.
- B. Өндөр болох тусам агаарын даралт буурч байна.
- C. Өндөр болох тусам агаарын даралт тогтмолжиж байна.
- D. Өндөр ба агаарын даралтын хооронд ямарваа зүй тогтол байхгүй байна.

28. Зургийг ажиглан асуултанд хариулаарай. Чи өөрийгөө өвлийн улиралд Номхон далайн эрэг дээр очсон байна гэж төсөөлөөрэй. Салхи хаанаас үлээх вэ? Учир шалтгааныг зөв тайлбарласан хувилбарыг сонгоорой. /2 оноо/




- A. Далайгаас эх газар луу үлээнэ. Учир нь далай дээр их даралт, эх газар дээр бага даралттай байна.
- B. Эх газраас далай руу үлээнэ. Учир нь эх газар дээр их даралт, далай дээр бага даралттай байна.
- C. Далайгаас эх газар луу үлээнэ. Учир нь эх газар дээр их даралт, далай дээр бага даралттай байна.
- D. Эх газраас далай руу үлээнэ. Учир нь далай дээр их даралт, эх газар дээр бага даралттай байна.

29. Уур амьсгалын диаграммаас 7 дугаар сарын хур тунадас ба агаарын температурыг зөв тодорхойлсон хариуг олно уу. /1 оноо/




- A. 7 дугаар сард 80мм тунадас, 16С дулаан байна.
- B. 7 дугаар сард 40мм тунадас, 10С дулаан байна.
- C. 7 дугаар сард 80мм тунадас, 8С дулаан байна.
- D. 7 дугаар сард 20мм тунадас, 6С дулаан байна.

30. Дэлхийн цэнгэг усны бүрэлдэхүүн хэсгийн зургийг ажиглаад “А” үсгээр тэмдэглэсэн усны төрлийг сонгоорой. /1 оноо/



- A. Хөрсөн дэх ус
- B. Гол
- C. Мөстлөг
- D. Амьд организм дахь ус

31. Гүний ус яагаад бохирддог шалтгааныг зургийг ажиглан тодорхойлж, үүнийг шийдвэрлэхэд дараах арга хэмжээнүүдийн аль нь эерэг нөлөө үзүүлж **ЧАДАХГҮЙ** болохыг дүгнэж тодорхойлно уу. /1 оноо/



- A. Жорлонг сар бүр ариутгах
- B. Гүний усны урсгалын доод хэсэгт жорлонг байрлуулах, худгийг дээд хэсэгт байрлуулах
- C. Жорлонгийн бохирдлыг хөрс, ус руу шингээхгүй байхаар үл нэвтрүүлэгч давхаргаар тусгаарлаж, бохирдлыг зайлуулж байх
- D. Усны чанарыг тогтмол хянаж, шинжилгээ хийлгэх

32. Цэгийн оронд тохирох үгийг сонгоорой. /1 оноо/
 бол хонхор газар хуримтлагдан тогтсон, далай тэнгистэй холбоогүй, экологийн өвөрмөц орчинг бүрдүүлдэг хуурай газрын усны нэг төрөл юм. /1оноо/

- A. Гол
- B. Нуур
- C. Намаг
- D. Тэнгис

33. Говийн бүсэд байрлах Улаан нууранд Онги гол цутгадаг. Сүүлийн жилүүдэд уул уурхайн олборлолтоос болж Онги гол тасарч, урсацын хэмжээ багассан. Тэгвэл Улаан нууранд ямар өөрчлөлт явагдах вэ? /1 оноо/

- A. Нуурын талбайн хэмжээ ихэссэн
- B. Нуурын талбайн хэмжээ багассан
- C. Нуурын ёроол илүү гүнзгий болсон
- D. Нуурын усны түвшин нэмэгдсэн

34. Гол 5500 м өндрөөс эх авч урсаад 2000 м өндөрт орших нуурт цутгажээ. Голын урт 350 км бол унал ба хэвгийг олоорой. /1 оноо/

- A. Унал-7500м, хэвгий 20,5 м/км
- B. Унал-3500 м, хэвгий 10 м/км
- C. Унал- 3500 м, хэвгий 0,1 м/км
- D. Унал-7500м, хэвгий 10,5 м/км

35. Тодорхойлолтуудыг зөв харгалзуулаарай. /1 оноо/

- 1. Биоценоз
- 2. Биогеоценоз
- 3. Биотоп
- 4. Био мандал

- a. Нэг төрлийн орчинд орших ургамал, амьтан, бичил биетний харилцан холбооны нэгдэл
- b. Бүх төрлийн амьд организм амьдардаг газарзүйн бүрхэвчийн хүрээ
- c. Байгалийн нэг төрлийн хүчин зүйлс бүхий нутаг дэвсгэрийн хэсэг
- d. Биоценоз орчинтойгоо нэгдэж үүссэн бүлгэмдэл

A.1b2a3d4c

B.1a2c3b4d


C.1a2d3b4c

D.1a2d3c4b

36. Хөрсний үндсэн бүрэлдхүүндүүдийг сонгоорой. /1 оноо/


- A. Органик бодис, эрдэс чулуулаг, агаар, ус
- B. Органик бодис, мөхсөн амьтад, галт уулын чулуу
- C. Эрдэс чулуулаг, галт уулын чулуу, азот
- D. Эрдэс чулуулаг, далайн амьтны үлдэгдэл, агаар

37. Хөрсний үе давхаргыг харуулсан зургийг ажиглан, хөрсний хамгийн үржил шимтэй үеийг олоорой. /1 оноо/



ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

2.1 Дараах зургийг ажиглан асуулт даалгаврыг гүйцэтгэнэ үү. /5оноо/



1. Нар хаана эгц тусаж байна вэ?
/1 оноо/

.....

2. Өмнөд хагаст /1оноо/ :.....
Хойд хагаст /1оноо/:
улирал болж байна.

3. Мэлхийн зам дээр нар хэдэн градус
өнцгөөр тусахыг бодож олно уу.
/2 оноо/

$$H = 90^\circ - \varphi - \alpha$$


φ - Тухайн газрын өргөрөг

α - Нар эгц тусаж буй өргөрөг

.....

.....

2.2 Хүн амын шилжилтийн диаграммыг ашиглан дараах асуулт даалгаврыг гүйцэтгээрэй.
/5оноо/



1. Төрөлт, нас баралт нь өндөр, цэвэр өсөлт багатай үе шат аль нь вэ? /1оноо/
2. Төрөлт өндөр, нас баралт буурч, ердийн өсөлт харьцангуй өндөр үе шат аль нь вэ? /1оноо/.....
3. Хүн ам зүйн хямралд орж байгаа 2 улсыг нэрлэж бичнэ үү. /2 оноо/
1..... 2.....
4. Хүн амзүйн хямралд орсон улсууд хүн амдаа ямар бодлого барихыг дараах хувилбараас сонгоно уу. / 1 оноо/
A. Төрөлтийг хязгаарлах
B. Төрөлтийг дэмжих
C. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшинг нэмэгдүүлэх

2.3. Голуудын зарим үзүүлэлт, томъёог ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй./5оноо/

Гол	Урсгалын хурд м/с	Эх авсан өндөр ДТД	Голын цутгаж буй өндөр ДТД	Голын дундаж өргөн (метр)	Голын гүн (метр)
Сэлэнгэ	1.5	1176	456	160	5
Орхон	2.5	2700	601	250	3.5

Голын хөндлөн огтлолын талбай: $F=2/3 \times B \times H$;

(F-хөндлөн огтлолын талбай, B-голын өргөн, H-хамгийн их гүн)

Голын дундаж гүн: $H=F/B$; (H- голын дундаж гүн, F- хөндлөн огтлолын талбай, B-голын өргөн)

Голын унал: $H=H1-H2$; (H-голын унал, H1-Эх авсан өндөр, H2-голын адаг, цутгалын өндөр)

Голын усны зарцуулга: $Q=V \times S$ (Q-усны зарцуулга, V-урсгалын хурд, S-хөндлөн огтлолын талбай)

- A. Голын морфометрийн зарим үзүүлэлтийг тооцоолон бодоорой. /4 оноо/

Гол	Голын хөндлөн огтлолын талбай	Голын дундаж гүн	Голын унал	Голын усны зарцуулга
Сэлэнгэ				
Орхон				

Б. Голын усны зарцуулга хамгийн их голыг нэрлээрэй. /1 оноо/

ГУРАВ. ХАРИУЛТЫН ХЭСЭГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37

1.1	1.2	1.3

2.1	2.2	2.3	2.4	3.а-оноог бичих	3.б-оноог бичих